

## **ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ ТОЙМ**

(Мэдээлэл, лавлагаа)

*Г.Билгээ, П.Уранчимэг, Ц.Ариунаа*

### **АГУУЛГА**

#### **УДИРТГАЛ**

#### **НЭГ. ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

#### **ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ ТОЙМ**

##### **2.1.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС**

- 2.1.1.Эрх зүйн орчин
- 2.1.2.Холбооны Парламентын ордон
- 2.1.3.Парламентын ордны танхимууд
- 2.1.4.Парламентын хэвлэл мэдээлэл
- 2.1.5.Парламентын үйлчилгээний газар
- 2.1.6.Парламентын номын сан, судалгааны алба
- 2.1.7.Австралийн ардчиллын музей
- 2.1.8.Аюулгүй байдлын алба
- 2.1.9.Парламентын ордныг түрээслэх

##### **2.2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**

- 2.2.1.Эрх зүйн орчин
- 2.2.2.Үндэсний Ассамблейн ордон
- 2.2.3.Үндэсний Ассамблейн Тамгын газар
- 2.2.4.Үндэсний Ассамблейн Номын сан
- 2.2.5.Үндэсний Ассамблейн Төсвийн алба
- 2.2.6.Үндэсний Ассамблейн Судалгааны алба
- 2.2.7.Үндэсний Ассамблейн Фьючерс институт
- 2.2.8.Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны танхим
- 2.2.9.Үндэсний Ассамблейн Музей

##### **2.3.ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС**

- 2.3.1. Парламентын буюу Вэстминстерийн ордон
- 2.3.2. Эрх зүйн орчин
- 2.3.3. Вэстминстерийн ордны сэргээн засварлах хөтөлбөр
- 2.3.4. Вэстминстерийн ордны танхимууд
- 2.3.5. Парламентын номын сангууд
- 2.3.6. Виктория цамхаг буюу Парламентын архив

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

“Парламентын ордны хөгжлийн чиг хандлага ба гадаадын зарим орны парламентын ордны талаарх тойм” сэдэвт мэдээлэл, лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-д гүйцэтгэв.

### **Судалгааны захиалгын даалгавар:**

- бусад улсад төрийн ордны (парламентын ордны) эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам байдаг эсэх;
- бусад улсын парламентын ордны дотоод зохион байгуулалт, нэгж, албадын нийтлэг болон онцлог зохицуулалтын тухай;
- бусад улсын парламентын музейн тухай;
- бусад улсын парламентын номын сангийн тухай;
- бусад улсын парламентын төрийн ёслол, харуул, хамгаалалтын тухай;
- бусад улсын парламентын ордны засвар, үйлчилгээ, аюулгүй байдлын тухай.

### **Судалгааны зорилго:**

Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийг боловсронгуй болгох, шинэчлэн найруулах ажлын хүрээнд гадаадын зарим орны туршлагыг судлах.

### **Судалгааны хамрах хүрээ:**

Гадаадын зарим орны Төрийн ордны (Парламентын ордон) талаарх хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, парламентын музей, номын сан, төрийн ёслол, харуул хамгаалалт болон парламентын ордны засвар үйлчилгээ, аюулгүй байдлыг дараах улсуудын хүрээнд авч үзлээ:

- Австралийн Холбооны Улс;
- Бүгд Найрамдах Солонгос Улс;
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс.

### **Судалгааны бүтэц:**

Судалгаа нь бүтцийн хувьд (1) Парламентын ордны хөгжлийн чиг хандлага, (2) Гадаадын зарим орны парламентын ордны талаарх тойм гэсэн үндсэн хоёр хэсэгтэй. Хоёрдугаар хэсэгт Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын ордны талаар мэдээллийг оруулсан болно.

**Түлхүүр үг:** парламентын ордон, төрийн ордон, ордны тухай хууль тогтоомж.

**Key words:** parliamentary building, house of parliament, regulation for parliamentary building.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## НЭГ. ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Парламентын байр буюу ордон нь хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжийг хэлэлцэн баталдаг барилга юм. Олон улсад парламентын байрыг үндэсний хэлний онцлогоос хамаарч “building”, “capitol”, “hall”, “house”, эсхүл “palace” гэх мэт олон нэр томьёо хэрэглэж байна.

Аливаа парламентын ордон нь тухайн улсын алсын хараа, уламжлал, соёлыг илтгэж байдаг. Шилжилтийн үеийн орнууд өөрсдийн үзэл санаа, зорилгыг илэрхийлэх, үндэсний соёл, өвөрмөц онцлогийг бэхжүүлэхийн тулд парламентын ордноо дахин төлөвлөж байна. Мөн эртний уламжлал бүхий парламентууд ч түүхэн өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн хадгалахын зэрэгцээ шинэ технологи, ирээдүйн олон төрлийн шаардлагад нийцүүлэн өөрчлөхийн тулд ордноо сэргээн засварлаж, шинэчилж байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудын парламентын барилгуудын ирээдүйд технологийн дэвшил, тогтвортой байдлын асуудал, хувьсан өөрчлөгдөж буй улс төрийн динамик, хөгжиж буй архитектурын чиг хандлага зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Энд дан ганц парламентын барилгын архитектур, төлөвлөлтийн асуудал бус, нэг талаар парламентын тогтвортой үйл ажиллагаа, түүний ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, нөгөө талаар иргэдийн төрөө дээдлэх ёс уламжлал зэрэг асуудлууд болон парламентын ордноос гадна түүний нутаг дэвсгэр дээр баригдсан бусад барилгууд буюу олон нийттэй шууд харилцах, парламентын боловсрол олгох зэргийг дэмжсэн иж бүрэн цогцолборыг хөндөж байгаа хэрэг юм.

Парламентын барилгуудын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг багцалж үзвэл:

- **тогтвортой байдал ба байгаль орчны талаар** – тогтвортой байдлыг хангах, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх хариуцлагыг чухалчилж байна. Нүүрстөрөгчийн ул мөрийг багасгахын тулд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, эрчим хүч болон усны хэмнэлттэй систем, материалыг ашиглах, хог хаягдлыг бууруулах;
- **хүртээмжтэй байдал** – хүн бүр, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настай хүмүүс бүрэн ашиглах боломжтой, тэдэнд хүртээмжтэй байхаар гадаад болон дотоод төлөвлөлтийг нэн тэргүүнд тавих;
- **технологийн интеграц** – парламентын хуралдааны танхимуудын үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдал, холболтыг сайжруулахын тулд сүүлийн үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

- **аюулгүй байдал** – хууль тогтоогчид, ажилтнууд болон зочдыг хамгаалахын тулд аюулгүй байдлын арга хэмжээг нэн тэргүүнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, аюул заналхийллийг шийдвэрлэх хамгийн сүүлийн үеийн аюулгүй байдлын технологи, шилдэг туршлагын талаар мэдээлэлтэй байх;
- **төлөвлөлтийн уян хатан байдал** – цаг хугацааны явцад парламентын барилгуудын өөрчлөгдөж буй хэрэгцээ, чиг үүргийн дагуу уян хатан байдлаар төлөвлөх, мөн орчин, гадаад ба дотоод талбай нь төрөл бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулахад хялбар байх;
- **соёл, нийгмийн орон зай** - парламентын ордны төлөвлөлтийн уян хатан байдлаас хамаарч ордон дотор урлагийн галерей, үзэсгэлэнгийн талбай, олон нийтийг хамарсан соёл, нийгмийн арга хэмжээ зохион байгуулах санал санаачилгыг дэвшүүлэх;
- **соёл, архитектурын өвөрмөц байдал, бүтээлч хандлага** – парламентын барилгуудын соёл, түүх, архитектурын өвөрмөц байдлыг хадгалахын зэрэгцээ шинэлэг дизайны элементүүдийг бий болгох;
- **олон нийтийн оролцоо** – хууль тогтоогчид болон ард иргэд хоорондын харилцааг дэмжих олон нийтийн уулзалтын талбай, боловсролын байгууламж, зочдын төв зэрэг парламентын барилгуудыг төлөвлөх замаар олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
- **ил тод байдал ба хариуцлага** – мэдээллийг нээлттэй олон нийтэд хүргэх шинэ санаачилга нэвтрүүлэх замаар иргэдийн оролцоог хангах буюу парламентын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх технологийг нэвтрүүлэх;
- **зайнаас ажиллах боломж** – коронавируст халдвар (COVID-19)-ын тахлын үеийн туршлагыг харгалзан парламентын барилгуудыг зайнаас ажиллах, цахим хуралдааныг дэмжих үүднээс загварчлах, шинэчлэх шаардлагатай бөгөөд энэ нь онцгой нөхцөл байдлын үед ч парламентын төдийгүй төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг баталгаажуулах.

Парламентын барилгуудын цаашдын хөгжил нь орчин үеийн засаглалын хувьсан өөрчлөгдөж байгаа хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд түүх, соёлын ач холбогдол, өвөрмөц байдлыг хадгалах болон дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх хоёрын тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхыг парламентууд анхаарч байна.

## ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ОРДНЫ ТАЛААРХ ТОЙМ

### 2.1.АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Холбооны Парламентын ордон бол Австралийн Холбооны Улсын ардчиллын бэлгэдэл байдаг. Тус ордны барилга нь хүрээлэн буй орчинтойгоо бүрэн зохицдог бөгөөд барилгын дээвэр дээр зүлэг тарьснаар иргэд, зочид ордны дээвэр дээр алхах боломжтой болсон. Энэ нь ард түмэн төрөөс дээгүүр гэсэн санааг илэрхийлж байдаг. Тийм ч учраас Парламентын ордон нь Зул сарын баярын өдрөөс бусад өдрүүдэд олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байдаг.

Түүнээс гадна энэ жил Холбооны Парламентын ордны 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Ням гарагт “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулах тухай цахим хуудсаараа дамжуулан олон нийтийг оролцохыг урьсан байна.

Тус ордонд Австралийн Холбооны Улс (Австрали Улс)-ын Холбооны Парламентын хоёр танхим, Засгийн газар байрладаг.



#### 2.1.1.Эрх зүйн орчин

Австрали Улсад Холбооны Парламентын ордонтой холбоотой харилцааг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд тус ордны барилгыг барих,



засварлах, Холбооны Парламентын ордон, түүний нутаг дэвсгэр дээр байрлах барилгыг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Тухайлбал:

1. Барилгын тухай хууль<sup>139</sup>, барилгын холбогдох стандартууд – Барилгын тухай хуулиар ерөнхийдөө барилга, барилгын ажил болон бусад холбогдох эрх зүйн харилцааг зохицуулна. Харин барилгын стандартууд нь барилгын аюулгүй байдал, тусгай хэрэгцээт иргэдэд хүртээмжтэй байдал, дэд бүтцэд тавигдах зэрэг шаардлагуудыг тогтоож өгсөн байдаг.
2. Австрали Улсын дэлхийн өвийн тухай хууль<sup>140</sup> – Энэ хууль нь тус улсын үндэсний байгалийн, соёл, түүхийн өвийг хамгаалах, хадгалах, танилцуулах, хойч үедээ өвлүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцааг зохицуулах ба энэ хуулиар түүхэн соёлын өвийн үнэт барилгыг бүрэн бүтнээр нь хамгаалах, түүний бүтцийг өөрчлөхийг хориглож, зарим хязгаарлалтыг тогтоож өгсөн. Парламентын ордон нь соёлын өвийн үнэт барилга учраас энэ хуулиар хамгаалагддаг.
3. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын журам, стандарт – Парламентын гишүүд, Парламентын ордонд ажиллагсад болон түр нэвтэрсэн зочдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Эдгээрт, Яаралтай нүүлгэн шилжүүлэх журам, Галын аюулгүй байдлын журам, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт зэрэг орно.
4. Хүртээмжтэй байдлын тухай хууль<sup>141</sup> – Парламентын ордныг хүн бүхэн тэр дундаа тусгай хэрэгцээт хүмүүсийн хүртээмжтэй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн харилцааг Хүртээмжтэй байдлын тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулиар тогтоосон шаардлагын дагуу Парламентын ордон доторх тэргэнцэр болон бусад хэрэгсэл ашиглах хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, өндөр настай иргэнд зориулсан налуу зам, цахилгаан шат, ариун цэврийн өрөөг төлөвлөх, болзошгүй аюулын талаарх мэдээлэл (анхааруулах, шаардлагатай бол)-ийг байрлуулах зэрэг төлөвлөлтийн онцлог шаардлагуудыг тодорхойлсон байна.
5. Парламентын ордонд мөрдөх бусад эрх зүйн актууд<sup>142</sup> – Парламентын үйлчилгээний газар (Department of Parliamentary Services)-аас эрх бүхий бусад байгууллагатай хамтран баталсан Парламентын ордонд мөрдөх дараах эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:

<sup>139</sup> Building Act 2004. <https://www.legislation.act.gov.au/View/a/2004-11/current/html/2004-11.html>

<sup>140</sup> Australian World Heritage laws. <https://www.dcceew.gov.au/parks-heritage/heritage/laws/world>

<sup>141</sup> Disability Discrimination Act 1992. <https://www.legislation.gov.au/Details/C2018C00125>

<sup>142</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Parliamentary\\_departments/Department\\_of\\_Parliamentary\\_Services/policies](https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_departments/Department_of_Parliamentary_Services/policies)



- Парламентын ордны CCTV ашиглалтын заавар (Australian Parliament House CCTV Code of Practice Guidance);
- Парламентын ордны цахилгааны хяналтын системийн ашиглалтын заавар (Australian Parliament House EACS Code of Practice Guidance);
- Парламентын ордонд ёслолын арга хэмжээ зохион байгуулах (Use of the Parliament House facilities for functions and events);
- Парламентын ордны тамхины бодлого (Parliament House smoking policy);
- Парламентын номын сангийн үйлчилгээний журам (Parliamentary Library Statement of Client);
- Парламентын ордон түүний тойрогт жагсаал, цуглаан болох үед баримтлах бодлого (Protest and other assemblies in the Parliamentary precincts policy);
- Парламентын ордны хувийн автомашины зогсоолын бодлого (Parliament House Private Car Parks Policy);
- Парламентын ордны тусгай бүсэд нэвтрэх бодлого (Parliament House Private Area Access Policy).

### 2.1.2.Холбооны Парламентын ордон

Австрали Улсын нийслэл Канберра хотын төв цэг болох Капитал толгод дээр байрладаг Холбооны Парламентын шинэ ордон (Парламентын ордон) нь 1988 онд ашиглалтад орсон бөгөөд 200 жил ашиглах зориулалттай ажээ.




Парламентын ордон нь 250.000м<sup>2</sup> талбайтай, 4700 өрөө тасалгаатай, нийт 3 давхар (газар дор 1 давхар, газар дээр 2 давхар) бөгөөд Парламентын хуралдаантай үед 5000 албан хаагч ажилладаг томоохон байгууламж юм.<sup>143</sup>

Парламентын ордны гол онцлог нь барилгыг үндсэн дөрвөн хэсэгт хуваасан бумеранг хэлбэртэй хоёр муруй хана юм. Энэхүү хоёр муруй хана нь Сенат болон Төлөөлөгчдийн танхимыг тусгаарлаж, Австрали Улсын хоёр танхимтай парламентын тогтолцоог илэрхийлдэг.<sup>144</sup>

Парламентын ордны барилгын бүтэц нь:

- зүүн хэсэгт - Төлөөлөгчдийн танхим болон гишүүдийн ажлын өрөө
- баруун хэсэгт - Сенат болон сенаторуудын ажлын өрөө;
- төв хэсэгт - урд талбай буюу Их веранда;
- урд хэсэгт - Ерөнхий сайд, сайд нарын өрөө тус тус байрладаг байна.



### 2.1.3. Парламентын ордны танхимууд

Сенатын болон Төлөөлөгчдийн хуралдааны танхимууд нь Парламентын ордон доторх хамгийн том танхимууд бөгөөд танхимууд нь тус улсын байгалийн унаган төрхийг илэрхийлсэн улаан хүрэн болон саарал ногоон өнгөтэй байдаг.

Холбооны Парламентын хоёр танхимуудын гэрэлтүүлгийг нарны эрчим хүчээр бүрэн хангасан нь цахилгааны зардлыг нэг жилд 17.000 доллар

<sup>143</sup> <https://peo.gov.au/>


<sup>144</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-house/australias-parliament-house/>

хэмнэдэг ажээ. Ордны энэхүү эрчим хүчний шийдэл нь Австрали Улсын Цэвэр эрчим хүчний зөвлөлөөс «цахилгаан эрчим хүчний системийн шилдэг дизайн, суурилуулалт» шагналыг хүртэж байжээ.<sup>145</sup>

### ***а) Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдааны танхим***

Төлөөлөгчдийн танхим 151 гишүүдээс бүрдэх ба гурван жилийн хугацаагаар ард түмнээс сонгогддог. Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдааны танхим нь бүхэлдээ тус улсын байгалийн унаган төрхийг илэрхийлсэн саарал ногоон өнгөтэй. Хуралдааны танхим доторх суудлуудыг англи хэлний “U” хэлбэрээр байрлуулсан байдаг. Төлөөлөгчдийн танхимын дарга нь “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын төвийн дээд хэсэгт тусгайлан зассан суудалд сууж, хуралдааны дэгийг сахиулдаг.

Түүний баруун талд Засгийн газрын гишүүд, зүүн талд сөрөг хүчний гишүүд сууна. Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдийнхээ өмнөх төв суудалд, сөрөг хүчний дарга нар өөрсдийн бүлгийн гишүүдийн өмнөх төв суудалд тус тус сууна. Төлөөлөгчдийн танхим дахь жижиг намууд болон бие даагчид “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын дугуйрсан хэсэгт сууна.



Хуралдааны танхимын дүр төрх, зарим дотоод зохион байгуулалт, зарим үйл ажиллагаа нь Их Британийн Парламентаас гаралтай ч Австрали Улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулагчид парламентын зохион

<sup>145</sup> Summit 2021, Australian Clean Energy.



байгуулалтыг шийдэхдээ АНУ-ын Конгрессын загварыг харгалзан үзсэн ажээ. Тухайлбал, “Төлөөлөгчдийн танхим”, “Сенат” гэсэн нэрийг АНУ-аас нутагшуулж авсан байна. Иймд өнгөрсөн зуунд Австрали Улсын Төлөөлөгчдийн танхим нь Их Британийн Парламент болон АНУ-ын Конгрессын аль алиных нь шинж, өнгө төрхийг агуулсан өөрийн гэсэн өвөрмөц хэв маяг, дэг журамтай болсон.

Танхимын бельэтаж (хуралдаан даргалагчийн ар талд болон танхимын хоёр талаар)-д зочид, төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, иргэд, олон нийтэд хуралдааны үйл явцыг ажиглах боломжтой нээлттэй хэсэг (нийт 528 хүний суудалтай) байдаг.

### **б) Сенатын нэгдсэн хуралдааны танхим**

Сенат нь 76 сенатораас бүрдэнэ. Сенатын нэгдсэн хуралдааны танхим нь бүхэлдээ улаан хүрэн өнгөтэй. Хуралдааны танхим доторх суудлуудын зохион байгуулалт нь Төлөөлөгчдийн танхимынхтай адилхан байдаг. Сенатын Ерөнхийлөгч нь “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын төвийн дээд хэсэгт тусгайлан зассан суудалд сууж, хуралдааны дэгийг сахиулдаг. Түүний баруун талд Засгийн газрын гишүүд, зүүн талд Сенат дахь сөрөг хүчний гишүүд сууна. Ерөнхий сайд нь Засгийн газрын гишүүдийнхээ өмнөх төв суудалд, сөрөг хүчний дарга нар өөрсдийн бүлгийн гишүүдийн өмнөх төв суудалд тус тус сууна. Сенат дахь жижиг намууд болон бие даагчид “U” хэлбэрээр байрлуулсан суудлуудын дугуйрсан хэсэгт сууна.



Тус танхимын зочид, төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, иргэд, олон нийтэд хуралдааны үйл явцыг ажиглах боломжтой нээлттэй хэсэг нь мөн Төлөөлөгчдийн танхимынхтай адилхан хуралдаан даргалагчийн ар талд болон танхимын хоёр талд бельэтажид байдаг.


### **в) Парламентын хороодын танхимууд**

Парламентын ордон нь хороодын 19 танхимтай. Эдгээрийн хамгийн том нь Үндсэн хорооны танхим юм. Энэ танхимыг Үндсэн хорооны хуралдаан, нийтийн сонсгол, хурал, хэвлэлийн бага хурал хийх зориулалттай болгон тохижуулсан байна.



### **г) Их танхим**

Их танхим (The Great Hall) бол ёслолын болон бусад албан ёсны арга хэмжээнд зориулагдсан том танхим юм. Австралид ургадаг модоор цонхны хүрээ, шал, ханын хавтанг хийсэн байна.



### **д) Гишүүдийн танхим**

Парламентын ордны төв хэсэгт Гишүүдийн танхим (the Members Hall) байрладаг. Тодруулбал, танхим нь барилгын хойд-өмнөд тэнхлэг ба зүүн-баруун тэнхлэгийн огтлолцол дээр, Сенат ба Төлөөлөгчдийн танхимын дунд байрладаг.

Энэхүү танхим нь Парламентын гишүүдийн албан бус уулзалтын газар нь болдог.



### е) Засгийн газрын танхим

Парламентын ордны 1 дүгээр давхарт Ерөнхий сайдын өрөөний эсрэг талд, бусад сайд нарын өрөөтэй нэг жигүүрт Засгийн газрын танхим байрладаг.

Засгийн газрын танхим нь байгалийн гэрэлгүй барилгын цөөхөн өрөөнүүдийн нэг ажээ.



## 2.1.4. Парламентын хэвлэл мэдээлэл

Парламентын ордон доторх хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг дараах эрх зүйн актуудаар зохицуулж байна. Үүнд:

1. Парламентын ордон, түүний тойрогт хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулах журам<sup>146</sup> – Уг журмыг парламентын ордонд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид дагаж мөрдөнө. Эдгээрт Хэвлэлийн галерейн (Press Gallery) үндсэн ажилчид, Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын гишүүд, Парламентын ордонд зочилж байгаа бусад хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, гадаадын хүндэт зочдыг дагалдан яваа олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид тус тус хамаарна;
2. Парламентын ордонд гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх журам<sup>147</sup> – Парламентын ордонд ажилладаг улс төрчид, албан хаагчид, Парламентын ордонд нэвтрэх үнэмлэх эзэмшигчид болон түр нэвтэрсэн зочдод мөн хамаарна;
3. Парламентын үйл ажиллагааг радиогоор дамжуулахад баримтлах зарчим<sup>148</sup> болон холбогдох тогтоолууд<sup>149</sup>.

Парламентын үйл ажиллагааг ABC телевиз, радио, A-PAC (Австралийн олон нийтийн суваг) болон Парламентын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд дамжуулдаг.<sup>150</sup>

<sup>146</sup> The Rules for Media Related Activity in Parliament House, 2016

<sup>147</sup> Guidelines for filming and photography in Parliament House, 2008

<sup>148</sup> General principles relating to the radio broadcasting of parliamentary proceedings - [https://www.aph.gov.au/Parliamentary\\_Business/Committees/House\\_of\\_Representatives\\_Committees?url=jcbpp/principles.htm](https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House_of_Representatives_Committees?url=jcbpp/principles.htm)

<sup>149</sup> Standing determinations relating to the radio broadcasting of parliamentary proceedings - [https://www.aph.gov.au/Parliamentary\\_Business/Committees/House\\_of\\_Representatives\\_Committees?url=jcbpp/determinations.htm](https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House_of_Representatives_Committees?url=jcbpp/determinations.htm)

<sup>150</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/house-of-representatives/house-of-representatives/>

### ***а) Парламентын хэвлэлийн галерей (press gallery)***

Австрали Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт зааснаар “Хэвлэлийн галерей” нь Холбооны Парламентын үйл ажиллагааг ард түмэндээ тайлагнах эрхэм зорилготой.

Хэвлэлийн галерей нь телевиз, радио, сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг 250 орчим итгэмжлэгдсэн сэтгүүлч, зураглаач, редактор зэрэг ажилтнуудаас бүрддэг.<sup>151</sup> Хэвлэлийн галерей нь Парламентын ордонд өргөн нэвтрүүлгийн студи, сэтгүүлчдийн ажлын өрөө, Сенат болон Төлөөлөгчдийн танхимын хуралдааныг дээрээс нь үзэж нэвтрүүлэх тусгай талбайтай.



Хэвлэлийн галерей нь Парламентын ордны Сенатын жигүүрийн 2 дугаар давхарт байрладаг.


### ***б) Хэвлэлийн галерейн гишүүнчлэл***

Хэвлэлийн галерейд ажиллах зөвшөөрлийг Парламентын үйлчилгээний газраас олгодог ба энэхүү зөвшөөрлийг олгохдоо дараах шалгуурыг хангасан эсэхийг харгалзан үздэг. Эдгээрт:

- зөвшөөрөл хүсэгч хэвлэл мэдээллийн байгууллага нь Хэвлэлийн галерейд гишүүнээр элсэх болзол хангасан эсэх;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын уншигч, сонсогч, эсвэл үзэгчдийн тоо;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үзэгч, сонсогч голчлон Австрали Улсад байдаг эсэх;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын улс төр, парламентын ордны мэдээнд ажиллах нийт сэтгүүлчдийн тоо;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын хэдэн сэтгүүлч өдөр бүр Хэвлэлийн галерейд ажиллах боломжтой тухай;
- тухайн хэвлэл мэдээллийн байгууллага одоогоор Хэвлэлийн галерейд ажиллах зөвшөөрөлтэй сэтгүүлч, ажилтнууд ажиллуулж буй эсэх;
- хүсэлт гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага чухал гэж үзсэн бусад хүчин зүйлсийг нэрлэж болно.

<sup>151</sup> <https://pressgallery.net.au/>






### 2.1.5. Парламентын үйлчилгээний газар

Парламентын үйлчилгээний газар (Department of Parliamentary Services) нь Австрали Улсын Парламентад бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Парламентын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг дөрвөн газрын нэг бөгөөд үйл ажиллагаагаа Сенатын Ерөнхийлөгч ба Төлөөлөгчдийн танхимын даргад тайлагнадаг. Парламентын үйлчилгээний газар 3500 гаруй ажилтантай.<sup>152</sup> Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын холбогдох нэгжтэй хамтран Парламентын үйлчилгээний газар дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

<sup>152</sup> [https://www.aph.gov.au/about\\_parliament/parliamentary\\_departments/departments\\_of\\_parliamentary\\_services](https://www.aph.gov.au/about_parliament/parliamentary_departments/departments_of_parliamentary_services)

- номын сан, судалгааны үйлчилгээ;
- мэдээлэл, харилцаа холбооны технологийн үйлчилгээ;
- аюулгүй байдлын үйлчилгээ;
- барилга, өвийн менежментийн үйлчилгээ;
- аудио дүрс болон хансард (hansard) үйлчилгээ;
- урлагийн бүтээлийн цуглуулга, үзэсгэлэнгийн үйлчилгээ;
- тавилга, хөрөнгийн менежментийн үйлчилгээ;
- зочдод зориулсан үйлчилгээ, Парламент бэлэг дурсгалын дэлгүүр;
- зоогийн газар, үсчин гоо сайхны үйлчилгээ;
- танхимуудын түрээсийн үйлчилгээ;
- зөвшөөрөлтэй жижиглэн худалдаа, эрүүл мэнд, банк санхүү, хүүхэд асрах үйлчилгээ;
- Парламентын үйлчилгээний газарт зориулсан корпорац, захиргааны үйлчилгээ.<sup>153</sup>



## 2.1.6. Парламентын номын сан, судалгааны алба

Парламентын номын сан нь Парламентын ордны 2 дугаар давхарт Сенатын жигүүрт байрладаг. Парламентын номын сан анх 1901 онд байгуулагдсан ба Парламентад мэдээлэл, дүн шинжилгээ, зөвлөгөө өгөх найдвартай эх сурвалж болж ирсэн байна.<sup>154</sup>

<sup>153</sup> Department of Parliamentary Services Annual Report 2022

<sup>154</sup> [https://www.aph.gov.au/about\\_parliament/parliamentary\\_departments/parliamentary\\_library](https://www.aph.gov.au/about_parliament/parliamentary_departments/parliamentary_library)

Парламентын үйлчилгээний тухай хуульд<sup>155</sup> зааснаар номын сан нь Парламентын үйлчилгээний газарт харьяалагддаг. Номын сан нь:

- номын сан;
- судалгааны алба;
- мэдээллийн албанаас бүрдэнэ.

Судалгааны алба нь 80 гаруй судлаач, ажилтантай бөгөөд судалгааг дараах зохион байгуулалтаар хуваарилан гүйцэтгэдэг. Үүнд:

- Эдийн засгийн судалгааны хэсэг;
- Гадаад хэрэг, аюулгүй байдлын судалгааны хэсэг;
- Эрх зүй болон хуулийн төслийн шинжилгээний хэсэг;
- Улс төр болон нийтийн удирдлагын судалгааны хэсэг;
- Шинжлэх ухаан, технологи, хүрээлэн буй орчин, байгалийн баялгийн судалгааны хэсэг;
- Нийгмийн бодлогын судалгааны хэсэг;
- Статистик, график дүрслэлийн судалгааны хэсэг.

Судалгааны алба судалгаа, шинжилгээ хийхдээ Судалгааны захиалга хүлээн авах журам, Судалгааны ажил гүйцэтгэх заавар, Хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх журам болон холбогдох бусад заавар, журмыг дагаж мөрдөнө.

Номын сан болон судалгааны албаны харилцагчид нь:

- Парламентын гишүүд, сенаторууд, улс төрийн намууд;
- хоёр танхимын Тамгын газрын болон Байнгын хорооны ажлын албаны ажилчид, албан хаагчид байна.<sup>156</sup>

### 2.1.7. Австралийн ардчиллын музей

Парламент нь шинэ ордон руу нүүсний дараа Парламентын хуучин ордныг 2009 оноос Австралийн ардчиллын музей болгон өөрчилсөн байна.

Ардчиллын музей үнэ төлбөргүй бөгөөд иргэдэд нээлттэй. Энд сурагчдын аялал, бүлгийн аялал, кафе түрээс, бэлэг дурсгалын дэлгүүр байрладаг бөгөөд парламентын ордны танхимууд, цэцэрлэгт хүрээлэнг олон нийтийн арга хэмжээнд зориулан түрээсэлж болдог байна. Хуучин парламентын ордон нь соёлын өвд тооцогдох бөгөөд байгалийн гэрэл сайтай, үзэмж төгс өв соёлыг агуулсан гайхалтай газар юм. Энд гала оройн зоог, хурим зэрэг 50-500 зочид бүхий арга хэмжээ зохион байгуулж болдог байна.<sup>157</sup>

<sup>155</sup> Parliamentary Service Act 1999. <https://www.legislation.gov.au/Details/C2019C00092>

<sup>156</sup> Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УИХ-ын Тамгын газар. 2012 он.

<sup>157</sup> <https://www.moadoph.gov.au/about/venue-hire>

### 2.1.8. Аюулгүй байдлын алба

Аюулгүй байдлын алба (Parliamentary Security Service) нь Парламентын ордонд орчин үеийн олон төрлийн хамгаалалтын чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Парламентын үйлчилгээний газарт харьяалагддаг. Аюулгүй байдлын алба нь 24 цагийн турш ажилладаг бөгөөд дараах чиг үүрэгтэй. Үүнд:

1. хүн болон эд хөрөнгийн Парламентын ордонд нэвтрэх шалгалт;
2. хандалтын хяналт;
3. хөдөлгөөнт эргүүл;
4. аюулгүй байдлын зөрчилд яаралтай хариу арга хэмжээ авах;
5. анхны тусламж, яаралтай тусламж үзүүлэх зэрэг орно. Гэхдээ тухайн нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлт хариу арга хэмжээ авахыг хуулиар зөвшөөрдөг байна.<sup>158</sup>

### 2.1.9. Парламентын ордныг түрээслэх

Австрали Улсын Парламентын ордонд ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдийг түрээсээр зохион байгуулахыг зөвшөөрдөг дэлхийн цөөхөн парламентын ордны нэг юм. Канберра хотод зохион байгуулагддаг томоохон ёслолын арга хэмжээний ихэнхийг тус ордонд зохион байгуулдаг бөгөөд тус улсын хамгийн том, хамгийн чухал үйл явдлууд энд өрнөдөг ажээ.

Парламентын ордонд 20 зочны оройн зоогоос эхлээд 1000 хүний томоохон арга хэмжээ хүртэл бүх төрлийн хурал, уулзалт, оройн, өдрийн зоогийн арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг байна.<sup>159</sup> Тухайлбал, тус ордны Их танхим, Ханын танхим, Хатан хааны дэнж, галерей, кафе, Гантиг үүдний танхим (фойе), Театр, урд талбай буюу Их веранда, хоолны өрөөнүүд, цэцэрлэгүүд зэрэг нийт 14 талбайд түрээсийн үйлчилгээ үзүүлдэг талаар Парламентын ордны цахим хуудсанд мэдээлсэн байна. Түрээсийн үйл ажиллагааг Парламентын үйлчилгээний газрын тусгай арга хэмжээний менежментийн баг хариуцдаг.<sup>160</sup>

<sup>158</sup> [https://www.aph.gov.au/About\\_Parliament/Employment/Department\\_of\\_Parliamentary\\_Services/Role\\_of\\_the\\_Parliamentary\\_Security\\_Service](https://www.aph.gov.au/About_Parliament/Employment/Department_of_Parliamentary_Services/Role_of_the_Parliamentary_Security_Service)

<sup>159</sup> <http://www.parliamenthousecateringbyihg.com.au/>

<sup>160</sup> [https://www.aph.gov.au/Visit\\_Parliament/Venue\\_Hire#greathall](https://www.aph.gov.au/Visit_Parliament/Venue_Hire#greathall)

Эдгээрээс Парламентын ордны урд талбай буюу Их верандаг авч үзвэл, 196 метр квадрат мозайкаар Австрали Улсын үүслийг дүрсэлсэн ажээ. Уг дүрслэлийг зохион бүтээсэн зураач Майкл Нелсон Жагамар бүтээлээ хүмүүс бүгд цугларан уулзалддаг газрыг илэрхийлсэн, эдгээр мөрөөдөл бол бидний амьдарч буй энэ улсын нэг хэсэг бөгөөд энэ газар нутаг бид бүх австраличуудын хувьд ямар утгатай болохыг тайлбарлахыг хичээсэн хэмээн өгүүлжээ.



Урд талбай буюу Их веранда бол Парламентын ордны олон нийтийн нүүр царай болж зочдыг хүлээн авах, ёслолын арга хэмжээ зохион байгуулагддаг.


## 2.2.БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс (Солонгос Улс)-ын Үндэсний Ассамблейн эрх мэдлийг хэрэгжүүлэх, хууль тогтоох үйл ажиллагааг мэргэжлийн, үр дүнтэйгээр зохион байгуулах, дэмжих бүрэлдэхүүн харьяа байгууллагуудтайгаа цогцолбор байдлаар оршдог.



Үндэсний Ассамблей цогцолбор нь Солонгос Улсын Сөүл хотод байрлах 330.000м<sup>2</sup> талбайд баригдсан бөгөөд Үндэсний Ассамблейн ордон, Гишүүдийн ажлын байр, Номын сан, Төсвийн алба, Судалгааны алба зэрэг нийт 12 барилга байгууламж бүхий цогцолбор юм.





### 2.2.1.Эрх зүйн орчин

Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүн байгууллагууд нь Солонгос Улсын Үндсэн хууль, Үндэсний Ассамблейн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллахаас гадна зарим байгууллагууд нь бие даасан хуулиудаар үйл ажиллагаагаа зохицуулдаг байна. Үүнд:

- Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хууль (National Assembly Secretariat Act);
- Үндэсний Ассамблейн Номын сангийн тухай хууль (National Assembly Library Act);
- Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хууль (National Assembly Research Service Act)

Үндэсний Ассамблейн Фьючерс Институт (National Assembly Futures Institute) нь бие даасан хуулийн төслөө боловсруулан хэлэлцүүлж байна. Үндэсний Ассамблейн барилгуудын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс аюулгүй байдал, галын аюулгүй байдлын хамгаалалт, Үндэсний Ассамблейн танхимын ашиглалт, зочид, иргэд, олон нийт дотогш нэвтрэх, хүн бүр (тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн)-д хүртээмжтэй байлгах, барилгын бүрэн бүтэн байдлыг хамгаалах, засварлах зэрэг олон чиглэлийн дүрэм, журам, стандартуудыг мөрддөг байна.

## 2.2.2. Үндэсний Ассамблейн ордон

Үндэсний Ассамблейн ордон нь газар доор 1, дээш долоон давхар чулуун байгууламж бөгөөд зүүн хэсэгтээ байрлах Үндэсний Ассамблейн цогцолборын хамгийн том, дан барилга юм.

Боржин чулуун 24 багана, цэнхэр бөмбөгөр орой, цагаан гадна талтай Үндэсний Ассамблейн ордон нь архитектурын үзэсгэлэнт бүтээл юм. Энэхүү түүхэн барилгыг зургаан жил барьсны эцэст 1975 онд барьж дуусгажээ. Боржин чулуун 24 багана, цэнхэр бөмбөгөр орой нь нэгдмэл байдал, олон нийтийн олон ургалч үзлийг бэлгэддэг байна.



Бусад орны парламентын ордны нэгэн адил Үндэсний Ассамблей нь Зочны төвтэй бөгөөд энэ нь Үндэсний Ассамблейн үндсэн чиг үүрэг болон барилгын бүтцийн талаар мэдээлэл өгөх бөгөөд барилга доторх нийтийн эзэмшлийн зарим хэсгийг үзэж, танилцах нэвтрэх эрхийг журмын дагуу олгоно. Мөн урьдчилан захиалга өгсөн зочдод Үндэсний Ассамблейн номын сан, Үндэсний Ассамблейн ордон, чуулганы танхим зэрэг бусад газруудаар аялах боломжтой аж.

Үндэсний Ассамблейн ордонд зочлохын тулд Зочдын төвд хүсэлт гаргана. Ингэхдээ иргэний үнэмлэхтэй байх ёстой. Хэрэв улс төрчид, бодлого тодорхойлогчдыг харах сонирхолтой бол зарим хуралдаантай танилцах, хурлын үндсэн хэсэгт аялах боломжтой байдаг.

Үндэсний Ассамблейн ордон нь Ханганг голын дэргэдэх Зочдын төв, алхах талбай, зочид амрах сандлаас бүрдэнэ. Барилгын урд хэсэг нь эргэн тойрон ногоон зүлэг, цэцэгт ургамал, усан оргилуур, хөшөө байх бөгөөд түүгээр зугаалах боломжтой, цэлгэр цэцэрлэг юм.




Ордон нь төв зам, метроны буудлын ойролцоо байрладаг тул нийтийн тээврээр зорчин ирж танилцах боломжтой. Хэрэв иргэн бага насны хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, эсхүл өндөр настай хүнтэй хамт хувийн машинаар явж байгаа бол машинаа зогсоолд байрлуулахыг зөвшөөрдөг.

Тэргэнцэртэй хүнд зориулсан хаалга нь өдөр бүр 24 цаг нээлттэй байна.



Үндэсний Ассамблейн цогцолбороор явах явган аяллын маршрут:

Үндэсний Ассамблейн музей → Үндэсний Ассамблейн номын сан → Үндэсний Ассамблейн байр → Үндэсний Ассамблейн танхим → Үндэсний Ассамблейн төв хаалга → Үндэсний Ассамблейн музей



### Автомашины зогсоол ашиглалтын мэдээлэл:

Үндэсний Ассамблейн цогцолборын автомашины зогсоолд зөвхөн албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн үйлчилгээний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хамгаалалт шаардлагатай бусад тээврийн хэрэгслийг байрлуулахыг зөвшөөрдөг. Жуулчид болон энгийн зочид Ханганг голын эрэг дээрх автомашины зогсоол дээр машинаа байрлуулдаг байна.

Үндэсний Ассамблейн автомашины зогсоол нь 2 цаг үнэгүй үйлчилгээ үзүүлдэг. Ингэхдээ Үндэсний Ассамблейн ордны зочдын төв, эсхүл Үндэсний Ассамблейн музейн мэдээллийн төвөөс зогсоолын тасалбараа тамгалуулдаг байна.

### 2.2.3. Үндэсний Ассамблейн Тамгын газар

Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төсөв, бүртгэл тооцоог хянах, зохион байгуулах болон захиргааны үйл ажиллагааг удирдан явуулах зорилгоор Үндэсний Ассамблейн Тамгын газрыг<sup>161</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн<sup>162</sup> 21 дүгээр зүйл).

<sup>161</sup> Үндэсний Ассамблейн Тамгын газрын цахим хуудас.

<sup>162</sup> Үндэсний Ассамблейн тухай хуулийн 21 дүгээр зүйл., [https://elaw.klri.re.kr/kor\\_service/lawView.do?lang=ENG&hseq=57599&joseq=JO0046030](https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=57599&joseq=JO0046030)

Үндэсний Ассамблейн Тамгын газар нь Үндэсний Ассамблейн гишүүн, хорооны хүсэлтийн дагуу Үндэсний Ассамблейн хууль тогтоох, төсвийн хяналт шалгалт, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай зүйлсээр хангаж, туслалцаа үзүүлнэ.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын тухай хуулийг (National assembly secretariat act)<sup>163</sup> 1963 онд баталсан бөгөөд хамгийн сүүлд 2020 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Хууль нь 4 бүлэг, 13 зүйлтэй. Хуулийн зорилго нь *“Үндэсний Ассамблейн Тамгын газрын зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг зохицуулахад оршино”* гэжээ.

Тамгын газрыг Ерөнхий нарийн бичгийн дарга удирдах бөгөөд Үндэсний Ассамблейн дарга намын бүлгүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр нэгдсэн хуралдаанаар томилж, чөлөөлнө.

Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор Үндэсний Ассамблейн үйл ажиллагаанд хяналт тавьж, өөрийн харьяанд байгаа төрийн албан хаагчдыг удирдан чиглүүлж, хяналт тавих үүрэгтэй.

Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэд:

- хууль тогтоох асуудал, хорооны ажлыг дэмжих чиг үүрэгтэй Хууль тогтоох асуудал эрхэлсэн орлогч;
- төлөвлөлт, төсөв санхүү, хүний нөөц, гадаад харилцаа, сургалт, олон нийтийн хэвлэл мэдээллийн төлөвлөлт зэрэг Захиргааны асуудал эрхэлсэн орлогч байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын чиг үүрэг нь хууль тогтоогчдын үйл ажиллагааг бүхэлд нь дэмжих, парламентын хуралдааныг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл хэлэлцэх, төсөв, тооцоо, төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт, мөрдөн байцаалтад туслахаас эхлээд парламентын гадаад харилцааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, иргэний ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

<sup>163</sup> National assembly secretariat act., [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=54178&type=lawname&key=NATIONAL+ASSEMBLY+SECRETARIAT+ACT](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=54178&type=lawname&key=NATIONAL+ASSEMBLY+SECRETARIAT+ACT)

### **а) Үндэсний Ассамблейн харуул хамгаалалтын алба**

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 144 дүгээр зүйлд Үндэсний Ассамблейн харуул хамгаалалтын алба, цагдаагийн харуулын тухай тусгаж өгсөн байна.



Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалтыг хангах зорилгоор Үндэсний Ассамблейн бүрэлдэхүүнд харуул хамгаалалтыг томилон ажиллуулна.

Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалтад шаардлагатай гэж үзвэл Үндэсний Ассамблейн дарга Танхимын Удирдах хорооны (House Steering Committee) зөвшөөрлөөр үндэсний цагдаагийн албан хаагчдыг тогтоосон хугацаанд ирүүлэх хүсэлтийг Засгийн газарт гаргадаг байна.

Үндэсний Ассамблейн ордны гаднах цагдаагийн харуул болон хуралдаан болж буй танхимын доторх дэг журмыг сахиулах, аюулгүй байдал, харуул хамгаалалтыг Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор явуулна. Үндэсний Ассамблейн цагдаагийн харуул нь Сөүл хотын цагдаагийн газарт харьяалагддаг байна.

Үндэсний Ассамблейн Тамгын газрын бүтцийн нэгжид *Үндэсний Ассамблейн аюулгүй байдлын алба* байдаг бөгөөд дараах үндсэн үүргийг хэрэгжүүлдэг байна.

- Үндэсний Ассамблейн аюулгүй байдал, хамгаалалт;
- Үндэсний Ассамблейн зочдын аюулгүй байдал, хамгаалалт;
- Үндэсний Ассамблейн ордонд зочлох зочдод үзүүлэх дэмжлэг, аюулгүй байдлын үзлэг, шалгалт;
- Зочны үнэмлэх олгох, зочдод зааварчилгаа өгөх, удирдан зохион байгуулах;
- Терроризмоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлуудыг (кибер терроризмоос бусад) хариуцан ажилладаг байна.

(Үндэсний Ассамблейн хамгаалалт, музейн хамгаалалт, Үндэсний Ассамблейн цогцолборын хамгаалалт, гадна талбай, авто зогсоолын хяналт, зогсоолын дарааллын хяналт, хуралдааны танхимын хамгаалалт, нөхцөл байдлын иж бүрэн хяналтын камерын хяналт, CCTV хяналт, цахим хандалтын системийн удирдлагын хяналт гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлдэг байна)

### **б) Үндэсний Ассамблейн засвар үйлчилгээ**

Тамгын газрын бүтцийн нэгж болох *Товчооны алба* (관리국) нь Менежментийн, Байгууламжийн, Тоног төхөөрөмжийн гэсэн 3 хэлтэстэй. Товчооны албаны үндсэн үүрэг нь:

- Үндэсний Ассамблейн өмчийн менежментийн асуудал;
- Үндэсний Ассамблейн ордны засвар үйлчилгээ, тохижилттой холбоотой асуудал;
- Чуулганы танхимын ерөнхий удирдлагын асуудал;
- Механик, цахилгаан, холбооны хэрэгслийн засвар үйлчилгээ, засварын менежментийн асуудал;
- Барааны менежментийн асуудал;
- Гамшиг, аюулгүй байдлын ослоос урьдчилан сэргийлэх, арилгах, байгууламжид учирсан хохирлыг арилгахтай холбоотой асуудлуудыг тус тус хариуцан ажилладаг байна.

#### **2.2.4. Үндэсний Ассамблейн Номын сан**

Үндэсний Ассамблейн ном, хууль тогтоомжийн материалтай холбоотой асуудлыг зохицуулахын тулд Үндэсний Ассамблейн номын сан<sup>164</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн номын сан нь ном, тогтмол хэвлэл, нийтлэл, мультимедиа болон цахим материал, түүнчлэн нийгэм, хүмүүнлэгийн ухааны эх сурвалжуудыг цуглуулах, цуглуулгыг хөтлөх, хууль тогтоох болон хяналтын үйл ажиллагаатай холбоотой төрөл бүрийн мэдээлэл цуглуулах, шаардлагатай тоо баримтуудыг гаргах, дүн шинжилгээ хийх, эмхэтгэх, цуглуулах, мэдээллээр хангах чиг үүрэгтэйгээс гадна олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байлгах үүрэгтэй.



Үндэсний Ассамблейн номын сан нь хууль тогтоогчдын хууль тогтоох үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор байгуулагдсан бөгөөд олон нийтийн хүсэж буй асуудал, хууль тогтоомжийн талаар шаардлагатай мэдээллийг цуглуулах, хадгалах, түгээн дэлгэрүүлэх, цуглуулсан материалтай танилцах боломжийг ажлын бус цагаар ч олон нийтэд нээлттэй олгодог.

<sup>164</sup> Үндэсний Ассамблейн номын сангийн цахим хуудас.,



Үндэсний Ассамблейн номын сангийн тухай хуулийг (National Assembly Library Act)<sup>165</sup> анх 1988 онд баталсан бөгөөд хамгийн сүүлд 2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Хуулийн зорилго нь Үндэсний Ассамблейн намын сангийн зохион байгуулалт, чиг үүрэг, бусад асуудлыг зохицуулахад чиглэгдэнэ.



Үндэсний Ассамблейн номын сан нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. (Үндэсний Ассамблейн номын сангийн тухай хуулийн 2 дугаар зүйл) Үүнд:

1) Үндэсний Ассамблейн номын сан нь Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагааг дэмжин ажиллана:

- номын сангийн сан хөмрөгийг цуглуулах, боловсруулах, хадгалах, номын сангийн үйлчилгээ үзүүлэх;
- хууль тогтоох байгууллага, хууль тогтоомжтой холбоотой судалгаа хийх, асуулгад хариу өгөх, мэдээлэл өгөх;
- Үндэсний Ассамблейн дижитал номын сан байгуулж ажиллуулах;
- Үндэсний Ассамблейн хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг цуглуулах, боловсруулах, хадгалах, үнэлэх, ашиглах;
- хууль тогтоох үйл ажиллагааны үндэсний ном зүйг бэлтгэх, стандартчилах;
- дотоод, гадаадын хууль тогтоох байгууллагуудын бусад номын сангуудтай хамтран ажиллах;
- Хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай бусад асуудал.

<sup>165</sup> National Assembly Library Act., [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=56084&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=56084&lang=ENG)

2) Номын сан нь Үндэсний Ассамблейгаас бусад төрийн байгууллагад номын сангийн үйлчилгээ үзүүлж болно. Бусад байгууллага гэдэгт орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн байгууллага, боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг орох ба иргэд, олон нийтэд үйлчилгээ үзүүлнэ. Ингэхдээ номын сангийн үйлчилгээг ашиглах эрх олгох бөгөөд үүнийг журмаар зохицуулдаг байна.

## 2.2.5. Үндэсний Ассамблейн Төсвийн алба

Төсөв, төсвийн төлбөр тооцоо, улсын сан, санхүүгийн менежмент, санхүү, бүртгэлтэй холбоотой асуудлыг судлах, дүн шинжилгээ хийх, дүгнэх, парламентын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн Төсвийн алба (국회예산정책처)<sup>166</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн Төсвийн алба (National Assembly Budget Office - NABO) нь парламентын санхүүгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор байгуулагдсан санхүүгийн асуудлаар мэргэшсэн, хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байгууллага бөгөөд мэргэжлийн, бодит судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан улсын төсөв, төсвийн гүйцэтгэл хэлэлцэхэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2003 оны 10 дугаар сарын 20-ны өдөр NABO нь үйл ажиллагаагаа эхлүүлж анхны дарга нь томилогдсон бөгөөд 2004 оны 03 дугаар сарын 03-ны өдөр өөрийн гэсэн байр, мэргэшсэн ажилтнуудтай болсон байна. Үндэсний Ассамблейн Төсвийн алба нь нэг даргатай (Chief), Төсвийн албыг удирдах бөгөөд Танхимын Удирдах хорооны зөвшөөрснөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.

Төсвийн алба нь дараах чиг үүрэгтэй ажилладаг байна. Үүнд:

- төсвийн орлого, зарлага, санхүүгийн тооцоо, сангийн үйл ажиллагааны тооцоо, сангийн төлбөр тооцоонд судалгаа, дүн шинжилгээ хийх;
- төсөвт мөнгө болон бусад хөрөнгийг ашиглах шаардлагатай үнэт цаасны зардлыг тооцоолох;
- улсын болон макро эдийн засгийн санхүүгийн чиг хандлагын талаар дүн шинжилгээ хийх, таамаглал гаргах;
- төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төслүүдэд дүн шинжилгээ хийх, үнэлэх;
- улсын дунд болон урт хугацааны санхүүгийн төсөөлөл гаргах;
- Үндэсний Ассамблейн хороо, гишүүдийн хүсэлтээр дүн шинжилгээ хийх.

<sup>166</sup> Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас., [www.korea.nabo.go.kr](http://www.korea.nabo.go.kr)



## 2.2.6. Үндэсний Ассамблейн Судалгааны алба

Хууль тогтоомж, бодлоготой холбоотой асуудлаар судалгаа хийх, холбогдох материал, мэдээллээр хангах замаар парламентын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн Судалгааны алба<sup>167</sup> байгуулна (Үндэсний Ассамблейн тухай хуулийн 22-3 дугаар зүйл).

Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хуулийг (National assembly research service act) 2007 оны 01 дүгээр сард баталсан бөгөөд хуулийн зорилго нь “Үндэсний Ассамблейн Судалгааны албаны зохион байгуулалт, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг шийдвэрлэхэд оршино.” гэжээ.

Үндэсний Ассамблейн Судалгааны албыг Үндэсний Ассамблейн даргын удирдлага дор байгуулах бөгөөд судалгааны албаны бие даасан байдлыг хүндэтгэн үзнэ гэж хуульд тусгаж өгсөн байна.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба (NARS) нь хууль тогтоох, бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх зорилгоор Үндэсний Ассамблейн хүрээнд байгуулагдсан бие даасан бодлогын судалгааны хүрээлэн юм. Судалгааны алба нь хууль тогтоомж, бодлогын асуудлаар судалгаа шинжилгээг бодитой, мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, шаардлагатай материалуудыг цуглуулах, боловсруулах, түгээх чиглэлээр ажилладаг байна.

Үндэсний Ассамблейн гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагааг дэмжих зорилгоор Үндэсний Ассамблейн тухай хууль, Үндэсний Ассамблейн Судалгааны албаны тухай хуулийг тус тус үндэслэн 2007 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан бодлогын судалгаа, шинжилгээний мэргэжлийн байгууллага юм.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь нэг даргатай (Chief), Судалгааны албыг удирдах бөгөөд Танхимын Удирдах хорооны зөвшөөрснөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.

- БНСУ-ын бүхий л салбарт мэргэшсэн цорын ганц мэргэжлийн судалгааны байгууллага болох Үндэсний Ассамблейн Судалгааны албаны ажилтнууд нь мэргэжлийн ур чадвар, төвийг сахих, нууцлалыг үндсэн үнэт зүйл болгон авч, асуудлыг олон талаас нь судалж, дүн шинжилгээ хийх бөгөөд хууль тогтоох болон бодлого боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүлдэг.

<sup>167</sup> Үндэсний Ассамблейн судалгааны албаны цахим хуудас., <https://www.nars.go.kr/index.do>

- Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь Үндэсний Ассамблейн гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагааг үнэнчээр дэмжиж, ард түмний төлөөллийн байгууллагын үүргээ биелүүлэх, ардчиллын төлөвшилд хувь нэмрээ оруулахад идэвхтэй дэмжлэг үзүүлэхийг эрмэлздэг.

Үндэсний Ассамблейн Судалгааны алба нь Үндэсний Ассамблейн хороод, Үндэсний Ассамблейн гишүүдээс хүссэн хууль тогтоомж, бодлого боловсруулахтай холбоотой асуудлыг шинжлэх ухаан, мэргэжлийн өндөр түвшинд судалж, дүн шинжилгээ хийн, хариултыг өгдөг.

## 2.2.7. Үндэсний Ассамблейн Фьючерс институт

Үндэсний Ассамблейн Фьючерс Институт (National Assembly Futures Institute)<sup>168</sup> нь орчны өөрчлөлтийг урьдчилан таамаглах, дүн шинжилгээ хийх, дунд болон урт хугацааны үндэсний хөгжлийн стратегийг боловсруулах, Үндэсний Ассамблейн бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх, үндэсний хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор 2018 оны 05 дугаар сард байгуулагдсан.



**Алсын хараа:** Үндэсний ирээдүйн стратегийг боловсруулах Үндэсний Ассамблейн Тинк Танк.

NAFI нь Үндэсний Ассамблейн даргын дэргэдэх шууд харьяа институт бөгөөд аль нэг намын харьяалалд байдаггүй, ирээдүйн урт хугацааны судалгааг улс төрийн нөлөөллөөс хараат бусаар тууштай явуулах зорилгоор байгуулагдсан. Институтын Удирдах зөвлөл нь Үндэсний Ассамблейн эрх баригч болон сөрөг хүчний тэнцүү тооны гишүүдээс бүрдэх бөгөөд судалгааны сэдэв, судалгааны үр дүнг эрх баригч болон сөрөг хүчний намуудын төлөөллөөс бүрдсэн Үндэсний Ассамблейн Удирдах хороонд тайлагнана. Мөн бүлэглэлээс ангид чадварлаг боловсон хүчин, мэргэжлийн судлаачид, судалгааны найдвартай, бодитой үр дүнгээр судалгааны институтын эрх мэдэл, бие даасан байдлыг баталгаажуулна.

<sup>168</sup> Үндэсний Ассамблейн Фьючерсийн институтын цахим хуудас., <http://www.nafi.re.kr>

### 2.2.8. Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны танхим

Үндэсний Ассамблейн Харилцаа холбооны байгууламж нь 4 давхар, нийт 24.732м<sup>2</sup> талбайтай Үндэсний Ассамблейн ордон болон Үндэсний Ассамблейн гишүүдэд зориулсан оффисын барилгын хажууд байрладаг.



Байгууламжийн 2, 3 дугаар давхарт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлэх танхим, сэтгүүлчдэд зориулсан, тоноглогдсон 125 хүний суудал бүхий мэдээллийн танхимтай Хэвлэлийн төв; өндөр тоноглол бүхий ухаалаг ажлын төв; 4 дүгээр давхарт нэмэлт оффисын танхимууд; газар доорх зогсоол, 1 дүгээр давхарт 1200 хүний суудал бүхий зоогийн газар, хүлээн



авалтын танхим, биеийн тамирын заал, жижиглэнгийн худалдааны талбай бүхий нийтийн үйлчилгээний газруудтай бөгөөд энэ нь төрийн албан хаагчид болон олон нийтэд үйлчилдэг байна.

## 2.2.9. Үндэсний Ассамблейн Музей

Үндэсний Ассамблейн Музей (National Assembly Museum)<sup>169</sup> нь Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа, Парламентын ардчилалтай холбоотой төрөл бүрийн материалыг Үндэсний Түр Ассамблейгаас өнөөг хүртэлх хугацаанд хадгалж, дэлгэн үзүүлдэг үндэсний нэгдүгээр зэрэглэлийн музей юм.



Музейн байр одоогоос 24 жилийн өмнө буюу 1998 онд “Үндсэн хуулийн дурсгалын ордон” (Constitution Memorial Hall) нэртэйгээр баригдсан. 2020 онд музейн үзэсгэлэнгийн талбайг системтэйгээр шинэчлэн зохион байгуулах зорилгоор анх удаа иж бүрэн засвар үйлчилгээ хийж 2022 онд “Үндсэн хуулийн дурсгалын ордон”-ы суурин дээр “Үндэсний Ассамблейн Музей” нэрээр дахин нээгдсэн байна.

Үндэсний Ассамблейн Музейн зорилго нь Үндэсний Ассамблей болон парламентын ардчиллын талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх төв, боловсролын газар болгоход чиглэгдэнэ.

Үндэсний Ассамблейн Музей нь газар доор 1 давхар, газар дээр 3 давхар барилгаас бүрдэх бөгөөд 2 дугаар давхартаа Үндэсний Ассамблейн түүхэн үйл явцын байнгын үзэсгэлэнгийн 1, 2, 3, 4 дүгээр танхим, тусгай үзэсгэлэнгийн танхим, 1 дүгээр давхарт хүүхдийн музей болон музейн зочдод зориулсан тав тухтай амрах орчин, талбайг бүрдүүлсэн.

Музейн ажиллах цагийн хуваарь нь Даваа – Баасан гарагт 10:00-18:00 цаг (17:00 цаг хүртэл орохыг зөвшөөрнө) Бямба гаригт 10:00-13:00 цаг (12:00 цаг хүртэл орохыг зөвшөөрнө) хүртэл, Ням гарагт амардаг байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>169</sup> Үндэсний Ассамблейн музейн цахим хуудас., <https://museum.assembly.go.kr/museum/main/main.do>

## 2.3.ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

### 2.3.1.Парламентын буюу Вэстминстерийн ордон

Их Британийн Парламент байрладаг Вэстминстерийн ордон бол дэлхийн хамгийн алдартай барилгуудын нэг бөгөөд хаант улсын ардчиллын гол цөм болж байдаг.

Вэстминстерийн ордны эдлэнд байрлах хамгийн эртний барилга болох Вэстминстер танхим нь 900 гаруй жилийн өмнө II Виллиам барьсан бөгөөд тухайн үед Европ дахь хамгийн том танхим гэж тооцогддог байжээ. XIII зуунаас тус танхимд Английн Парламент хуралдах болсон.



### 2.3.2.Эрх зүйн орчин

Вэстминстерийн ордны нутаг дэвсгэрдээрх барилгууд хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, явуулах арга хэмжээ өөр байхын хамт барилгуудад мөрдөх дүрэм, журам өөр өөр байдаг. Эдгээр дүрэм, журмууд нь тэдгээр барилгуудын аюулгүй байдал, үйл ажиллагааг хангахад чиглэгддэг.<sup>170</sup>

Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээр мөрддөг дүрэм, журам, удирдамж, төлөвлөгөөнүүдийг тоймлон үзвэл:

**а) Түүхэн болон соёлын өвийн хамгаалалт, хадгалалт** – Вэстминстерийн ордон нь ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн бөгөөд түүний архитектур, түүнд хадгалагдаж буй урлагийн үнэт бүтээлүүд, түүхийн баримт бичиг, эд өлгийн зүйлсийг хадгалахын тулд нэлээдгүй дүрэм, журам мөрддөг.

<sup>170</sup> <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/sn00485/>



- *Жагсаалтад орсон барилгууд (listed building)*: Архитектур, түүх, үндэсний онцлог шинж чанартай барилгуудыг уг жагсаалтад гурван зэрэгт ангилж оруулдаг. Энэ нь барилгын түүх, архитектурын бүрэн бүтэн байдлыг хадгалахын тулд аливаа өөрчлөлт, өргөтгөл, засварыг нарийвчилсан зааврыг баримталж хийх ёстой гэсэн үг. Вэстминстерийн ордон нь уг жагсаалтын I зэрэглэлд тодорхойлогдсон.
- *Хамгаалалтын бүсүүд (Conservation Areas)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэрийг хамгаалалтын бүс гэж тодорхойлдог. Энэ нь эдгээр газруудын шинж чанар, өнгө үзэмжийг хамгаалах нэмэлт зохицуулалт, тухайлбал, шинээр барих, хуучин барилгуудад өөрчлөлт оруулахыг хязгаарласан гэсэн үг юм.
- *Төлөвлөсөн эртний дурсгалт газрууд (Scheduled Ancient Monuments)*: Вэстминстерийн ордны зарим хэсэг, эсхүл түүний ойр орчмын газрыг эртний дурсгалт газруудаар тооцож болно. Энэ нь өндөр түвшний хамгаалалтыг санал болгодог бөгөөд эдгээр бүс дэх аливаа өөрчлөлт, хөгжил нь өвийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл шаарддаг. Түүнчлэн Английн түүхэн барилга, дурсгалт газруудыг хадгалах, хамгаалах үүрэгтэй Засгийн газрын өвийн агентлаг болох Түүхэн Англи (Historic England) нь Вэстминстерийн ордон болон бусад түүхэн дурсгалт газруудыг хамгаалах талаар заавар, зөвлөгөө өгч, хяналт тавьдаг.
- *Төлөвлөлтийн зөвшөөрөл (Planning Permission)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээр болон түүний ойр орчмын санал болгож буй аливаа өөрчлөлт, бүтээн байгуулалтыг төлөвлөлтийн зөвшөөрлийн дагуу хийнэ. Орон нутгийн төлөвлөлтийн байгууллага нь өвийн асуудал хариуцсан байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зөвшөөрөл олгохоос өмнө түүхэн болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийдэг.
- *Хамгаалалтын төлөвлөгөөнүүд (Conservation Plans)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээрх барилгууд нь байгаль хамгаалах талаар төлөвлөгөөтэй байдаг. Эдгээр төлөвлөгөөнүүд нь тэдгээр барилгуудыг хадгалах, сэргээн засварлах зарчим, зорилгыг тодорхойлж, үүнд материал, техник, дизайны талаарх тусгай удирдамж багтсан болно.

**б) Барилгын стандарт, дүрэм, журам** – Вэстминстерийн ордны байгууламжийн бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдал болон барилга угсралт, засвар үйлчилгээний бусад асуудалд тавигдах стандартыг тогтоосон үндэсний болон орон нутгийн барилгын стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

- *Галын аюулгүй байдал (Fire Safety)*: Вэстминстерийн ордон нь түүхэн ач холбогдолтой, үнэт бичиг баримт, эд өлгийн зүйл байдгаараа онцгой ач холбогдол бүхий объект болдог. Ордныг гал

түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах системийн бэлэн байдлыг хангах төдийгүй галын аюулгүй байдлын үзлэг, сургуулилыг тогтмол хийхтэй холбоотой дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг.

- *Хүртээмжтэй байдал (Accessibility)*: Вэстминстерийн ордныг хамгаалахын зэрэгцээ олон нийтэд хүртээмжтэй байлгахын тулд ордонд хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэлтгүй бүх хүн нэвтрэх, ашиглахтай холбоотой зохицуулалтын дүрэм, журмыг мөрддөг. Үүнд, налуу зам, цахилгаан шат, зориулалтын бие засах газар, тэмдэг тэмдэглэгээ зэрэг онцлогууд багтана. Мөн олон нийтэд Вэстминстерийн ордны түүхэн, соёлын ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хөтөчтэй аялал, боловсролын хөтөлбөрүүдийг явуулах дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг.
- *Парламентын гишүүд болон албан хаагчдад хүртээмжтэй байдал (Accessibility for Parliamentarians and government officials)*: Вэстминстерийн ордон нь олон нийтэд хүртээмжтэй байхаас гадна Парламентын гишүүд, төрийн албан хаагчдад ажлаа явуулах аюулгүй, үр ашигтай орон зайг хангахтай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрддөг.
- *Байгаль орчны зохицуулалт (Environmental Regulations)*: Вэстминстерийн ордны нутаг дэвсгэр дээрх барилгуудын эрчим хүчний хэмнэлт, тогтвортой байдал, орчны ногоон байгууламжтай холбоотой стандарт, дүрэм, журмыг мөрддөг.

**в) Аюулгүй байдал** – Вэстминстерийн ордон болон түүний дотор ажиллаж байгаа улс төрийн зүтгэлтнүүдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмууд нь Парламентын гишүүд болон зочдын аюулгүй байдлыг хангах үүднээс аюулгүй байдлын арга хэмжээнүүд багтаасан байдаг. Үүнд, нэвтрэх хяналт, хяналтын систем, хамгаалалтын ажилтнууд, аюулгүй бүсүүд, онцгой байдлын бэлэн байдал, харилцаа холбоо, зохицуулалт, болзошгүй эрсдэл, эмзэг байдлын аюулын үнэлгээ, кибер аюулгүй байдал, зочдод болон ажилтнуудад аюулгүй байдлын дүрэм, журмыг таниулах сургалт, сурталчилгааны ажил зэрэг багтдаг.

**г) Засвар үйлчилгээ, сэргээн засварлалт** – Вэстминстерийн ордон дотор аливаа үйл ажиллагаа, арга хэмжээг хэвийн зохион байгуулах, хэрэгжүүлэхийн тулд тус ордонд байнгын засвар үйлчилгээ, сэргээн засварлахтай холбоотой дүрэм, журам, төлөвлөгөөг мөрддөг. Мөн Вэстминстерийн ордны өвийг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн хадгалах, Их Британийн Парламентын ордон хэвээр байхын сацуу тус ордныг шинэ технологи, ирээдүйн шаардлагад нийцүүлэн өөрчлөхийн тулд томоохон засварын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага үүсэж 2019 онд тус улсын Парламентын хоёр танхимаас Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийг<sup>171</sup> баталсан.

<sup>171</sup>Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>



### 2.3.3. Вэстминстерийн ордныг сэргээн засварлах хөтөлбөр

2019 онд Вэстминстерийн ордны хоолой хагарснаас болж Парламентын танхимуудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь тус ордныг илүү өргөн хүрээнд сэргээн засварлах, шинэчлэх тухай яригдах болсон.

Парламентын хоёр танхимаас Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн дагуу Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөр (Restoration and Renewal Programm) хэрэгжүүлэх ба энэхүү хөтөлбөр нь Их Британийн өвийн шинэчлэлийн хамгийн том төсөл болж байна. Сэргээн засварлах ажил нь дараах хэсэгт хуваагдаж Вэстминстерийн ордны томоохон асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөж байна<sup>172</sup>:

- эрүүл мэнд, аюулгүй байдал – ордны 4000 хүрэл цонхыг сольж, асбестыг<sup>173</sup> арилгаснаар галын хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах;
- барилга доторх дэд бүтэц – ордон нь хуучирсан үйлчилгээтэй холбоотой 40.000 гаруй асуудлыг мэдээлсний дагуу сэргээн засварлах төлөвлөгөө нь бүх HVAC систем, ус зайлуулах суваг, сантехник, галын хамгаалалтын системийг солих;
- барилгын гадна фасад – тус ордны гадна фасадын чулуун хэсгүүд унах үед ноцтой асуудал үүсгэдэг тул тус асуудлыг шийдэх;
- олон нийтэд үзүүлэх түүхэн өв – сэргээн босголтын төлөвлөгөө нь энэхүү өвийн дурсгалт газарт хүн бүр ирж, үзэхэд тааламжтай, хүртээмжтэй болгох зорилготой;
- үйл ажиллагаа ба дизайн – шаардлагатай бүх аюулгүй байдлын арга хэмжээг багтаасан тус барилгыг ирээдүй хойч үедээ үлдээх, мөн харилцаа холбоог сайжруулах үүднээс ордонд мэдээлэл, харилцаа холбооны технологи суурилуулах;
- тогтвортой байдал – Парламентын үйл ажиллагаанд нийцсэн бөгөөд байгаль орчинд ээлтэй, тогтвортой шийдлүүдийг гаргах.

Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 19-28 жилийн хугацаа шаардагдах ажээ. Тус барилгыг хоосон байлгаж сэргээн засварлахад ихээхэн зардал, цаг хугацаа хэмнэх тул Парламентын хоёр танхим 12-20 жилийн хугацаанд Вэстминстерийн ордны гадна ажиллах аж.

<sup>172</sup><https://www.re-thinkingthefuture.com/architectural-styles/a7718-timeline-of-restoration-palace-of-westminster/>

<sup>173</sup> Асбест (asbestos) нь байгаль дээр тархсан гидросиликат магни, төмөр, кальци, натригаас тогтсон маш нарийнхан утсархаг бүтэцтэй, бутрамтгай чулуулаг эрдсүүд юм. Асбестийн бүлгийн эрдэс нь бат бэх, дулаан цахилгааныг бага дамжуулдаг, гадаад орчин, халуун, хүйтэн, галд болон химийн бодисын үйлчлэлд тэсвэртэй, удаан эдэлгээтэй зэрэг онцлог шинж чанаруудтай. Асбестийн 6 төрөл байдаг бөгөөд бүгд хүний биед онцгой хортой, хорт хавдар үүсгэгч бодис юм.

Сэргээн босгох, шинэчлэх хөтөлбөрийн ажил нь дөнгөж эхэлж байгаа бөгөөд одоогийн байдлаар тус хөтөлбөрийн Гүйцэтгэгч хэлтэс нь Парламентын Тамгын газартай хамтран сэргээн засварлах, шинэчлэх ажлын хамрах хүрээг тодорхойлж байна. Хамрах хүрээг тодорхойлж, энэ том төслийн иж бүрэн судалгааг хийж, зураг төслийг тохиролцсоны дараа ажлын арга барил, шаардлагатай зардлыг хоёр танхимын гишүүдэд танилцуулж шийдвэрлэнэ.

Дэлхийн хамгийн алдартай барилгуудын нэг болох Вэстминстерийн ордонг хойч үедээ үлдээхийн тулд их засвар хийх шаардлагатай ажээ. Түүнийг сэргээн засварлах хөтөлбөр нь Их Британийн аж үйлдвэрийг идэвхжүүлж эхлээд байгаа бөгөөд аль болох тус улсын бүтээгдэхүүнийг ашиглаж, инженер, дизайнер, мужаан, өрлөгчин зэрэг олон мэргэжилтнүүдийг ажлын байр, дадлага хийх боломжоор ханган ажиллаж байна.

2019 онд батлагдсан Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн<sup>174</sup> зорилго нь Вэстминстерийн ордныг сэргээн засварлах ажил болон Парламентын эдлэнд хамаарах бусад ажилтай холбоотой харилцааг зохицуулна.

Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулиар Вэстминстерийн ордны сэргээн засварлах ажлын оролцогч талууд, тэдний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлага, хариуцан тайлагнах үйл явц, оролцогч талууд хоорондын болон Парламент хоорондын харилцаа, Парламентын эрх, үүрэг, хэрэгжүүлэх үе шатууд, арга хэмжээнүүд болон түүнд аудит хийх зэрэг өргөн хүрээний харилцааг зохицуулсан байна.

Энэ хуулиар Вэстминстерийн ордныг сэргээн засварлах үүрэгтэй Парламентын ажлыг Ивээн тэтгэгч байгууллага (Parliamentary Works Sponsor Body)-ыг байгуулсан. Тус байгууллагын боловсруулсан Вэстминстерийн ордныг сэргээн засварлах хөтөлбөрийн зардал, хуваарийн анхны үнэлгээтэй Нийтийн танхимын хороо 2022 оны 01 дүгээр сард танилцаж, хоёр танхимын хороодын хамтарсан хуралдаанаар 2022 оны 03 дугаар сард Сэргээн засварлах, шинэчлэх хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар тохиролцон, Ивээн тэтгэгч байгууллагын чиг үүргийг Парламентад шилжүүлэх, эсхүл өөр байгууллагад шилжүүлэхийг санал болгосон байна.<sup>175</sup>

<sup>174</sup> Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>

<sup>175</sup> <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8968/>



2022 оны 07 дугаар сард Парламентын хоёр танхимын хороод уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хамтарсан хяналт тавихаар санал нэгдсэн байна.<sup>176</sup>

Парламентын барилгуудын (сэргээн засварлах, шинэчлэх) тухай хуулийн дагуу Сэргээн босгох, шинэчлэх хөтөлбөрийн захиргаа (Restoration and Renewal Programme governance) байгуулагдсан. Мөн Сэргээн засварлалтын ажлын зураг төсөл боловсруулах, гүйцэтгэх үүргийг Гүйцэтгэгч хэлтэс (Delivery Authority)-т олгосон байна.


2022 оны 09 дүгээр сард Лордын танхим ба Нийтийн танхимын шинэ хамтарсан хороо болох Сэргээн засварлах, шинэчлэх үйлчлүүлэгчийн зөвлөл (Restoration and Renewal Client Board)-ийг байгуулжээ. Тус зөвлөл нь хоёр танхимын спикерүүд, парламентын 15 гишүүн, мөн парламентын бус 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Зөвлөлийн парламентын бус 8 гишүүнд хоёр танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга (Clerk) нар, Нийтийн танхимын ерөнхий захирал, хоёр танхимын комиссын гадаад гишүүд орсон байна.

<sup>176</sup> <https://www.restorationandrenewal.uk/about-us/governance>

### 2.3.4. Вэстминстерийн ордны танхимууд

Өнөөдөр Вэстминстерийн ордон 3.24 га талбайг эзэлдэг бөгөөд 4 давхар, 1100 орчим өрөө, 100 шат, 4.8км гарцтай. Урд талын Виктория цамхагас хойд зүгт Цагтай цамхаг хүртэлх барилга нь бараг 300 метр урттай.

Тус ордонд олон тооны коридор, галерей байдаг бөгөөд ихэнх нь урлагийн бүтээлүүд, түүхэн олдворууд, Их Британийн улс төрийн зүтгэлтнүүдийн хөрөг зургууд байдаг.



СУДАЛГААНЫ САН



### **а) Вэстминстерийн танхим**

Вэстминстерийн танхим бол Парламентын ордны нутаг дэвсгэр дээрх хамгийн эртний барилга бөгөөд томоохон арга хэмжээнүүд зохион байгуулагддаг. Тус танхим нь уужим цэлгэр бөгөөд архитектурын гайхамшигт шийдэл бүхий тааз, дотоод засал нь Их Британид төдийгүй дэлхийд архитектурын гайхалтай бүтээлд тооцогддог.



### **б) Лордын Танхим**

Их Британийн Парламентын дээд танхим болох Лордын Танхимын хуралдааны танхимд парламентын гурван элемент (бүрэн эрхт ноёд, ард түмэн)-үүдийг нэгтгэсэн учир Вэстминстерийн ордны хамгийн тансаг чимэглэлтэй өрөөнд тооцогддог. Танхим дахь тавилга нь ихэвчлэн улаан өнгөтэй байдаг.



### **в) Нийтийн Танхим**

Парламентын доод танхим болох Нийтийн Танхимын урт сандал болон бусад тавилга нь 300 жилийн өмнөх уламжлалт ногоон өнгөтэй. Эсрэгцүүлж тавьсан урт сандлууд нь Их Британийн анхны байнгын ажиллагаатай Нийтийн Танхим болох Гэгээн Стефан сүмийн анхны зохион байгуулалтыг хадгалсан байна.



### **г) Төв лобби**

Төв лобби нь барилгын гол хэсэгт байрладаг бөгөөд дугуй хэлбэртэй, Вэстминстерийн ордны гол цөм болдог. Энэ нь Вэстминстерийн танхим, Парламентын хоёр танхимын уулзвар бөгөөд хоёр танхимын гишүүдийн уулзалт хийх газар, Парламентын гишүүд сонгогчидтойгоо уулзах газар болгон төлөвлөжээ.





### 2.3.5. Парламентын номын сангууд

Парламентын хоёр танхим тусдаа өөрсдийн номын сантай. Эдгээр түүхэн номын сангууд нь Парламентын түүхэн баримт бичиг, ном, тэмдэглэл зэрэг арвин сан хөмрөгтэй.

Номын сангууд нь хоёр танхимын гишүүд болон тэдний ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байна.

#### **а) Лордын Танхимын номын сан**

Лордын Танхимын номын сан нь Парламентын ажилд тусалж хууль эрх зүйн болон лавлах номоор хангах зорилгоор 1826 онд байгуулагджээ.

Тус номын сан нь Лордын Танхимд хэлэлцэж байгаа асуудлуудын талаар товч мэдээлэл, тойм, тухайн асуудлын Парламент дахь хэлэлцүүлгийн явц, сүүлийн үеийн үйл явдлуудыг танилцуулах үйлчилгээг Танхимд үзүүлдэг.

Номын сан нь 80.000 орчим түүхэн (тусгай) болон орчин үеийн ном, сэтгүүл, сонин, парламентын баримт бичгийн цуглуулгатай. Лордын Танхимын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудаас гадна иргэдэд номын сангийн үйлчилгээ үзүүлдэг. Тухайлбал, номын сангийн тусгай цуглуулгын талаар судалгаа хийх сонирхолтой иргэд Парламентын архиваар дамжуулан материалаа авах хүсэлт гаргана. Иргэд Лордын Танхимын үйл ажиллагаатай холбоотой лавлагааг цахимаар, эсхүл утсаар авах боломжтой байдаг.

Утасны лавлах үйлчилгээ нь Даваа-Пүрэв гараг хүртэл 10:00-17:00, Баасан гарагт 10:00-16:00 цагийн хооронд ажилладаг.

#### **б) Нийтийн Танхимын номын сан**

Нийтийн Танхимын номын сан нь тус Танхимын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудад хууль тогтоомжийн төслийг нягтлан шалгах, хэлэлцүүлэгт бэлтгэх, тухайлсан чиглэлээр бодлого боловсруулах, сонгогчдоо дэмжихэд туслалцаа үзүүлдэг.



Тус номын сангаас судалгааны тайлан, улс төрийн хувьд хараат бус дүн шинжилгээ, статистикийн мэдээлэл бэлтгэдэг.

### 2.3.6. Виктория цамхаг буюу Парламентын архив

Вэстминстерийн ордны хамгийн өндөр цамхаг бол Виктория цамхаг юм. Хатан хаан Викториягийн нэрээр нэрлэгдсэн, 98.5 метр өндөртэй энэ цамхаг олон жилийн турш дэлхийн хамгийн өндөр, хамгийн том чулуун дөрвөлжин цамхаг байв. Анхандаа хаан тус цамхагаар дамжиж ордон руу ордог байсан, мөн Парламентын бичиг баримтыг хадгалах зориулалттай байсан бөгөөд одоо Парламентын архивын байр болсон байна. Виктория цамхгийн хуучирсан өрлөгийг засах ажлыг 2024 онд эхлүүлэх төлөвтэй байна.

Парламентын архив нь Их Британийн Парламентын бүртгэлийг цуглуулж, хадгалж, тэдгээрийг Парламентын гишүүд болон түүний Ажлын албаны ажилтнуудад хүргэх үйлчилгээ үзүүлдэг. Мөн тус архив нь хоёр танхимд албан хэргийг хөтөлдөг.



Тус архивын сан хөмрөгт Их Британийн Парламентын үйл ажиллагаатай холбоотой түүхэн баримт бичиг, материал хадгалагддаг. Архивын сан хөмрөг нь ихэвчлэн органик материалаас (цаас, арьс шир, илгэн цаас, лав гэх мэт) бүрддэг. Сан хөмрөгийн цуглуулгыг механик гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчноос хамгаалж хадгалах, стандартын дагуу зөв зөөвөрлөхийг шаарддаг байна. Парламентын архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, зөөвөрлөлтийн ажлыг хариуцдаг.

Парламентын архив нь мөн сан хөмрөгөө олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлдэг. Олон нийтэд зориулсан архивын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Энэхүү үйлчилгээг архивын лавлагаа гаргах, бүлгийн аялал хийх, ордон дотор болон Вэстминстерийн нутаг дэвсгэрт үзэсгэлэн болон сурталчилгааны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, сан хөмрөгтэй цахимаар танилцах хэд хэдэн платформыг ажиллуулж байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Австралийн Холбооны Улс:

- Parliamentary Service Act 1999
- Application to use Formal Gardens
- Application to use Parliamentary Precincts - Authorised Assembly Area
- Australian Parliament House CCTV Code of Practice Guidance
- Australian Parliament House EACS Code of Practice Guidance
- Australian Parliament House Protest and other assemblies in the Parliamentary precincts policy
- Australian Parliament House Site Book Version 10.1 2022
- Department of Parliamentary Services Annual Report 2022
- General principles relating to the radio broadcasting of parliamentary proceedings
- Guidelines for filming and photography in Parliament House 2008
- Parliament House Private Area Access Policy
- Parliament House Private Car Parks Policy
- Parliament House smoking policy
- Parliament of Australia. Retrieved 26 December 2017.
- Parliamentary Library Statement of Client Services
- Rules for media related activity in parliament house and its precincts
- Standing determinations relating to the radio broadcasting of parliamentary proceedings
- Summit 2021, Australian Clean Energy.
- Use of the Parliament House facilities for functions and events
- <http://www.parliamenthousecateringbyihg.com.au/>
- <https://peo.gov.au>
- <https://pressgallery.net.au/>
- <https://www.abc.net.au>
- <https://www.legislation.act.gov.au/a/2004-11>

### Бүгд Найрамдах Солонгос Улс:

- Үндэсний Ассамблейн тухай хууль. <https://elaw.klri.re.kr>
- National Assembly Library Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- National Assembly Research Service Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- National Assembly Secretariat Act. <https://elaw.klri.re.kr/eng>
- Дэлхийн улс орнуудын парламентын ажлын алба. УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв. УБ., 2012 он. 154-158 хуудас.
- Үндэсний Ассамблейн цахим хуудас. <https://korea.assembly.go.kr>
- Үндэсний Ассамблейн Тамгын газрын цахим хуудас.
- Үндэсний Ассамблейн Номын сангийн цахим хуудас
- Үндэсний Ассамблейн Төсвийн албаны цахим хуудас., [www.korea.nabo.go.kr](http://www.korea.nabo.go.kr)

- Үндэсний Ассамблейн судалгааны албаны цахим хуудас. <https://www.nars.go.kr/index.do>
- Үндэсний Ассамблейн Фьючерсийн институтын цахим хуудас. <http://www.nafi.re.kr>
- Үндэсний Ассамблейн музейн цахим хуудас. <https://museum.assembly.go.kr/museum/main/main.do>
- [http://nationalatlas.ngii.go.kr/pages/page\\_573.php](http://nationalatlas.ngii.go.kr/pages/page_573.php)
- <https://krguide.kr/MNG/1149/contents.do>

**Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс:**

- Parliamentary Buildings (Restoration and Renewal) Act 2019. <https://www.legislation.gov.uk/ukpga/2019/27/enacted#printOptions>
- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Парламентын цахим хуудас. <https://www.parliament.uk/>
- <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8968/>
- <https://www.re-thinkingthefuture.com/architectural-styles/a7718-timeline-of-restoration-palace-of-westminster/>
- <https://www.restorationandrenewal.uk/about-us/governance>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН